



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ”
ТӨХК-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 219,071,821 /хоёр зуун арван есөн сая далан нэгэн мянга найман зуун хорин нэг/ ширхэг энгийн хувьцааг хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлсэнтэй холбогдуулан 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 51,664,618 /тавин нэгэн сая зургаан зуун жаран дөрвөн мянга зургаан зуун арван найм/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлж нийт 270,736,439 /хоёр зуун далан сая долоон зуун гучин зургаан мянга дөрвөн зуун гучин ес/ ширхэг хувьцаатай байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөн бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандуулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК /Ш.Доржрагчаа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000611